



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/439

Мянган тус

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.8, Төсвийн тухай хуулийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны ээлжит бус 10 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан-Уул сумын сум дундын эмнэлгийн 380 В-ын 4 кв-ын 1 насос, Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн 380 В-ын 1,5 кв-ын 1 насос тог тасарсны улмаас шатаж, иргэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх боломжгүй болсон тул эмнэлгүүдийн хэвийн нөхцөлийг хангахад зориулж Улаан- Уул сумын сум дундын эмнэлэгт 3,000,000 төгрөг, Баянзүрх сумын эрүүл мэндийн төвд 1,000,000 төгрөгний дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг "Эрүүл иргэн-Эрхэм баялаг" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД